Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/05/22 дүгээр албан бичгийн 01 дүгээр хавсралт

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	4	40
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**		100

____oOo____

Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын
газрын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны
өдрийн 11-05/13 дүгээр албан бичгийн
..2.. дугаар хавсралт

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ.Товч танилцуулга

ХЭҮК-ын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа ба бүрэлдэхүүнийг Тамгын газрын даргын 2025 оны А/83 дугаар тушаалаар шинэчлэн баталж, А/134 дүгээр тушаалаар бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, дарга шинэчлэгдэх тухай бүр ажлыг хүлээлцүүлэн ажил хүлээлцэх акт үйлдэж баримтжуулж ажилласан байна.

Ёс зүйн дэд хороо нь Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор 2025 онд 3 зорилт, 11 арга хэмжээ бүхий үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг хангаж, дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудаст “Ёс зүйн дэд хороо” цэсийг шинээр үүсгэн хөтөлж байгаа ба албан хэрэг хөтлөлтөд ашиглаж буй дотоод систем буюу эйбл системд нийт албан хаагчдад нээлттэй ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн санг үүсгэсэн тухай бүр мэдээллээр баяжуулан, албан хаагчид, иргэд олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.
- Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг ажиллуулах эрхийг Ёс зүйн хорооны ажлын албанаас Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргад олгосон бөгөөд тус дэд системд Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн мэдээлэл, дэд хороонд 2025 онд ирсэн гомдол, шийдвэрлэлтийг тус тус бүртгэн хөтөлж ажиллалаа.
- Тайлант онд Ёс зүйн дэд хороо нь нийт 7 удаа хуралдаж, хурлын тэмдэглэлийг тухай бүр бичиж, баталгаажуулан ажилласан байна.
- Ёс зүйн дэд хорооны хурлаар 3 гишүүн нь орон нутагт ажилладаг референт сонгогдсонтой холбогдуулан гарын үсгийн баталгаажуулалт хийхэд тоон гарын ашиглах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Энэ хүрээнд Комиссын Тамгын газрын даргад албан бичгээр хүсэлт хүргүүлж, тоон гарын үсэг ашиглах зөвшөөрөл, холбогдох төсвийг шийдвэрлүүлэн, тоон гарын үсэг авахад шаардагдах материал (дэд хорооны дарга гишүүдийн тоон гарын үсэг авах анкет, гэрээг бөглөж, И-МОНГОЛИА-ийн иргэний үнэмлэхийн лавлагаа)-ыг бүрдүүлж, холбогдох газарт хүргүүлэн, дарга, гишүүдийг тоон гарын үсэгтэй болгосон байна.
- Ёс зүйн дэд хорооны өмнө ажиллуулж байсан гомдол, мэдээлэл, санал хүсэлт хүлээн авах хайрцаг нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул 2025 онд шинээр 2 ширхэг хайрцгийг Комиссын байрлах байрны 1 болон 2 дугаар давхарт иргэд, албан хаагчдад харагдахуйц газарт ил байршуулан ажиллуулж байна. Тайлант хугацаанд хайрцагт гомдол, мэдээлэл, санал хүсэлт ирээгүй байна.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 4 арга хэмжээ зохион байгуулж, Удирдлагын академи, Ёс зүйн хороо, бусад газраас зохион байгуулсан 4 удаагийн сургалт, Комиссын Тамгын газар, Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан 4 удаагийн сургалтад албан хаагчдыг хамруулсан байна.

- Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын дагуу хийсэн ба үнэлгээний ажлыг хийх 11 арга хэмжээ бүхийг төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлсэн. Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээнд Тамгын газрын удирдах болон гүйцэтгэх 78 албан хаагчаас 77 хүн хамрагдсан бөгөөд хамрагдалтын хувь 98.7 хувьтай байна. (Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн 1 албан хаагч эрүүл мэндийн шалтгаанаар үнэлгээнд хамрагдаагүй байна) Үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын 11 нь удирдах, 66 нь гүйцэтгэх түвшний албан хаагч байх бөгөөд 46 эмэгтэй, 31 эрэгтэй албан хаагч байна. Тус үнэлгээний ажлын тайланг бичиж, цаашид авах арга хэмжээний саналын хамт Тамгын газрын даргад хүргүүлэн танилцуулсан байна.
- Ёс зүйн тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороонд нийт 4 гомдол мэдээлэл ирснээс 2 нь хүсэлт гаргаж гомдлоо буцаасан ба 2 гомдолд Ёс зүйн дэд хороо ажиллагааг явуулж, тус тус дүгнэлтийг гаргаж ажилласан байна.

ХОЁР.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Тайлант хугацаанд дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа: Үүнд:

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулах зорилгоор байгууллагын цахим хуудаст “Ёс зүйн дэд хороо” цэсийг шинээр үүсгэж, Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн танилцуулга, холбоо барих мэдээлэл, гомдол, мэдээлэл хүлээн авах тухай мэдээлэл, 2024, 2025 оны төлөвлөгөө, тайлан, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ холбогдох мэдээллийг албан хаагчид болон иргэд, олон нийт танилцах боломжтой байдлаар байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.
- Мөн Ёс зүйн дэд хорооны гишүүд болон албан хаагчдыг мэдээллээр хангах зорилгоор эйбл албан хэрэг хөтлөлтийн системийн олон нийт цэсийн файлын сан дотор Ёс зүйн дэд хорооны гишүүд харах дотоод мэдээллийн сан болон нийт албан хаагчдад нээлттэй ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн санг тус тус үүсгэсэн. Дээрх нээлттэй мэдээллийн санд дэд хороо байгуулсан шийдвэр, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг, хаалттай мэдээллийн санд дэд хорооны хурлын тэмдэглэл, төлөвлөгөө, гомдлын бүртгэл болон шалгах ажиллагааг явуулах хуваарь, бусад зохион байгуулалттай холбоотой баримт бичгийг тус тус байршуулан, тухай бүр баяжуулан ажиллаж байна.
- Ёс зүйн дэд хорооны өмнө ажиллуулж байсан гомдол, мэдээлэл, санал хүсэлт хүлээн авах хайрцаг нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул 2025 онд шинээр 2 ширхэг хайрцгийг Комиссын байрлах байрны 1 болон 2 дугаар давхарт иргэд, албан хаагчдад харагдахуйц газарт ил байршуулан ажиллуулж байна. Тайлант хугацаанд хайрцагт гомдол, мэдээлэл, санал хүсэлт ирээгүй байна.
- Төрийн албан хаагчийн ёс зүй болон дэд хороо үйл ажиллагаандаа мөрдлөг болгох хууль тогтоомжийн жагсаалтыг гаргаж, дэд хорооны гишүүдийг мэдээллээр хангасан ба Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн эмхэтгэлийг дэд хорооны гишүүд, Комиссын Тамгын газрын албан хаагчид танилцаж, судлах боломжтой байдлаар эйбл системийн олон нийт болон ТИЙМС группийн чатаар тус тус байршуулж, танилцууллаа.
- Ёс зүйн хорооноос гаргасан Ёс зүйн дэд хороонд гомдол хүлээн авах, хэрхэн шийдвэрлэх талаарх видео бичлэг, “Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ” видео бичлэгийг дотоодод ашиглаж буй систем эйбл болон ТИЙМС-д тус тус байршуулан Тамгын газрын албан хаагчдад танилцууллаа.

- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Удирдлагын академийн багш А.Алтанзулыг урьж “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг, дотоод нөөц боломжийн хүрээнд “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь”, “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх-ХАСХОМ гаргах”, “Жендэрийн мэдрэмжтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, Тамгын газрын албан хаагчдыг хамруулсан байна.

- Мөн Ёс зүйн хорооны 7:4:10 цахим мэдээллийн хөтөлбөрийн “Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал” сэдэвт сургалт, Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, Комисс хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй, хүний эрх” сэдэвт сургалтад удирдах 1, гүйцэтгэх 1 албан тушаалтан, Хүний хувийн мэдээллийн менежментийн тогтолцооны ахлах аудиторын сургалтад 1 албан хаагч, Жендэр судлалын мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулж, сертификат авсан байна.

- Шинэ ажилтны чиглүүлэх сургалтыг 6 удаа зохион байгуулж, хүний эрхийн ойлголт, хандлага, хүний эрхийн үндэсний байгууллагын чиг үүрэг, онцлог агуулгын хүрээнд сургалт мэдээлэл өгсөн. Нийт 13 албан хаагчийг хамруулсан. Сургалтаар хүний эрхийн байгууллагын онцлог, хүний эрхийн ойлголт хандлага, байгууллагын дотоод үйл ажиллагааны талаар сургалт, мэдээлэл өгсөн.

- Ёс зүйн хороо, Удирдлагын академи хамтран зохион байгуулсан салбарын түвшинд ёс зүйн сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг бие даан зохион байгуулах чадавхыг эзэмшсэн ёс зүйн сургагч багш бэлтгэх “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургагч багш” сургалтад 4 албан хаагчийн материалыг хүргүүлж, 1 албан хаагч шаардлагад тэнцэж сургагч багшийн сургалтад хамрагдахаар болсон байна.

- Тамгын газрын албан хаагчдын албан хаагчдын хууль эрх зүй, түүх, соёл, үнэт зүйл, танин мэдэхүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийн хүрээнд “АХА” тэмцээнийг зохион байгууллаа.

- Тамгын газрын албан хаагчдын дунд алдаа, оноогоо дэнсэлж, талархал илэрхийлэх, уучлал хүсэх замаар харилцан хүндлэл, ёс зүйтэй эерэг харилцааг түгээн дэлгэрүүлэх, итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор “Баярлалаа, уучлаарай” аяныг өрнүүлж, талархлын цахим дэвтэр үүсгэсэн байна.

- Тамгын газрын албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Ёс зүйн дэд хорооны мэдээллийн самбарыг шинээр байршуулан ажиллуулж байна.

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад "төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах", 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтад “хариуцсан салбар, байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг авах”, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 1.1.1-т "байгууллага албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ." гэж заасны дагуу Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөнд Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ хийх асуудлыг тусган хэрэгжүүллээ. Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын дагуу хийсэн ба үнэлгээний ажлыг хийх 11 арга хэмжээ бүхийг төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлсэн. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд:

- Эрсдэлийн үнэлгээнд хамрагдах Тамгын газрын үндсэн орон тоонд ажиллаж байгаа 78 албан хаагчийн нэрсийг гаргаж, албан тушаалын нэршлээр нь кодлох

- Ёс зүйн хорооноос эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбоотой файлыг авч, үнэлгээний нэгтгэл хийх эксэл файл дээр Тамгын газрын албан хаагч тус бүрээр багана нэмж томьёо оруулах, албан тушаалын кодыг шивэх зэрэг бэлтгэл ажлыг хангах
- Ёс зүйн хорооноос зохион байгуулах 7:4:10 цахим мэдээллийн хөтөлбөрийн "Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал сэдэвт сургалтын зарыг хүргэж, нийт албан хаагчдыг хамруулах
- Ёс зүйн хорооноос ирүүлсэн линк, QR кодоор албан хаагчдаас асуулга авах ажлыг зохион байгуулж, асуулгын дүнг урьдчилан оруулсан томьёо бүхий эксэл файл дээр албан тушаалын кодоор нь шивж оруулан дүнг нэгтгэх зэрэг ажлыг хийсэн байна.

Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээнд Тамгын газрын удирдах болон гүйцэтгэх 78 албан хаагчаас 77 хүн хамрагдсан бөгөөд хамрагдалтын хувь 98.7 хувьтай байна. (Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн 1 албан хаагч эрүүл мэндийн шалтгаанаар үнэлгээнд хамрагдаагүй байна) Үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын 11 нь удирдах, 66 нь гүйцэтгэх түвшний албан хаагч байх бөгөөд 46 эмэгтэй, 31 эрэгтэй албан хаагч байна. Тус үнэлгээний ажлын тайланг бичиж, цаашид авах арга хэмжээний саналын хамт Тамгын газрын даргад хүргүүлэн танилцуулсан байна. Тус үнэлгээний дүнг үндэслэн 11 албан тушаалтнаар ёс зүйн нөлөөллийн мэдүүлгийг гаргуулсан байна. Тус онд ёс зүйн зөрчил гаргаж, хариуцлага хүлээсэн албан хаагч байхгүй байна.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороонд нийт 4 гомдол мэдээлэл ирснээс 2 нь хүсэлт гаргаж гомдлоо буцааж, 2 гомдолд Ёс зүйн дэд хороо ажиллагааг явуулж, "Ёс зүйн зөрчил гаргаагүй" хэмээн дүгнэлт гаргасан бөгөөд ёс зүйн зөрчил гаргаж, хариуцлага хүлээсэн албан хаагч байхгүй байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулах зорилгоор Байгууллагын цахим хуудаст "Ёс зүйн дэд хороо" цэсийг шинээр үүсгэж, Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн танилцуулга, холбоо барих мэдээлэл, гомдол, мэдээлэл хүлээн авах тухай мэдээлэл, 2024, 2025 оны төлөвлөгөө, тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг тухай бүр байршуулан ажиллалаа.

2025 онд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд 2.4 сая төгрөг, гишүүдийн урамшуулалд 14.5 сая төгрөг, нийт 16.9 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна.

2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Дэд хорооны гишүүдийн харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагааг шуурхай тасралтгүй явуулах зорилгоор тиймс групп нээж, гишүүдийг бүртгэж, өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай явуулж байна. Үүнтэй холбогдуулан нууцлалыг хангах зорилгоор дарга, гишүүд ТИЙМС-ийн нууц кодоо сольсон бөгөөд гомдол мэдээллийг хүлээн авч бүртгэж байгаа бичиг хэргийн ажилтнаар нууцын баталгааг гаргуулан нууцлалыг хадгалахад анхааран ажилласан байна.

Ёс зүйн дэд хорооны хурлаар 3 гишүүн нь орон нутагт ажилладаг референт сонгогдсонтой холбогдуулан гарын үсгийн баталгаажуулалт хийхэд тоон гарын ашиглах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Энэ хүрээнд Комиссын Тамгын газрын даргад албан бичгээр хүсэлт хүргүүлж, тоон гарын үсэг ашиглах зөвшөөрөл, холбогдох төсвийг шийдвэрлүүлэн, тоон гарын үсэг авахад шаардагдах материал (дэд хорооны дарга гишүүдийн тоон гарын үсэг авах анкет, гэрээг бөглөж, и-монголиа-ийн иргэний үнэмлэхийн лавлагаа)-ыг бүрдүүлж, холбогдох газарт хүргүүлэн, дарга, гишүүдийг тоон гарын үсэгтэй болгосон байна.

Тайлант онд Ёс зүйн дэд хороо нь нийт 7 удаа хуралдаж, хурлын тэмдэглэлийг тухай бүр бичиж, баталгаажуулан ажилласан байна.

Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг ажиллуулах эрхийг Ёс зүйн хорооны ажлын албанаас Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргад олгосон бөгөөд

тус дэд системд Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн мэдээлэл, дэд хороонд 2025 онд ирсэн гомдол, шийдвэрлэлтийг тус тус бүртгэн хөтөлж ажиллалаа.

Ёс зүйн дэд хороонд ирсэн гомдлыг шалгах ажиллагааг гишүүдийн нэрсийн цагаан толгойн үсгийн дарааллаар явуулах хуваарийг гарган гишүүдэд танилцуулж, 2025 онд хуваарийн дагуу гомдол шалгах ажиллагааг явуулсан байна. Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороонд нийт 4 гомдол мэдээлэл ирснээс 2 нь хүсэлт гаргаж гомдлоо буцаасан ба 2 гомдолд Ёс зүйн дэд хороо ажиллагааг явуулж, дараах дүгнэлтүүдийг гаргасан байна. Үүнд:

- Иргэн А.Ж-аас Тамгын газрын албан хаагчтай холбоотой гомдлыг байгууллагын цахим шуудан (info@nhrcm.gov.mn)-гаар 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн ба шалгах ажиллагааг явуулж, Ёс зүйн дэд хорооны 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцэж, “Ёс зүйн зөрчил гаргаагүй” гэсэн 01 дүгээр дүгнэлтийг гаргасан байна.
- Иргэн З.Ө-аас Тамгын газрын нэр бүхий 4 албан хаагчтай холбоотой мэдээлэл гаргасныг Тамгын газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн ТГ-01.. дугаар албан бичгээр Ёс зүйн дэд хороонд шилжүүлэн ирүүлсэн ба шалгах ажиллагааг явуулж, Ёс зүйн дэд хорооны 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцэж, “Ёс зүйн зөрчил гаргаагүй” гэсэн 02 дугаар дүгнэлтийг гаргасан байна.

Дээрх Ёс зүйн дэд хороонд ирсэн гомдол, мэдээллийг Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд бүртгэж, шийдвэрлэлтийн мэдээллийг байгууллагын цахим хуудаст тухай бүр байршуулан ажиллаж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Тус онд байгууллагын цахим хуудаст “Ёс зүйн дэд хороо” цэсийг шинээр үүсгэж, төрийн албан хаагч ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний ажлыг хийж, Ёс зүйн дэд хорооны гишүүдийг тоон гарын үсэгтэй болгож, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг өмнөх оноос эрчимжүүлсэн зэрэг үр дүнтэй ажлуудыг зохион байгуулсан байна.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний ажлыг хийхэд албан тушаалын чиг үүрэг нь адилхан албан тушаалын нэг тодорхойлолттой албан хаагчдын эрсдэлийн түвшин нь албан хаагчид асуулгыг хэрхэн ойлгож бөглөж байгаагаас шалтгаалан өөр өөр тогтоогдсон. Үүнийг тухайн албан тушаалын эрсдэл гэж дүгнэхэд учир дутагдалтай байгаа бөгөөд тус үнэлгээний дүнг үндэслэн нэг албан тушаалын тодорхойлолттой албан хаагчдын зарим нь ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргаад зарим нь гаргахгүй байгаа нь байгууллагын албан хаагчдад ташаа ойлголтыг төрүүлэхээр байна. Эрсдэлийг тооцож урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа нь үр дүнтэй боловч, үнэлгээний үр дүнг үндэслэн ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргахад дээрх байдлаар бэрхшээл тулгарч байна.

____oOo____

БАТЛАВ.
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН
ДЭД ХОРООНЫ ДАРГА Т.ИХТАМИР

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 09 дугаар сарын 04 Улаанбаатар хот

Д/д		Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
	Нэг.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр				
1	1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.	Төсөв шаардахгүй	Улирал тутам	Ёс зүйн зөвлөл, мэргэжлийн байгууллага, ЁСДХ-ны гишүүд
2	2	Ёс зүйн хэм хэмжээ, үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх, хууль эрх зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор албан хаагчдын дунд “АХА” тэмцээн зохион байгуулах	Батлагдсан төсөв	Хагас, бүтэн жилд	ЁСДХ-ны гишүүд
3	3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар албан хаагчдад сургалт зохион байгуулах	Төсөв шаардахгүй	Тухай бүр	Авлигатай Тэмцэх газартай хамтран зохион байгуулах
4	4	“Баярлалаа”, “Уучлаарай” сэдэвт аян өрнүүлэх	Батлагдсан төсөв	Тогтмол	ЁСДХ-ны Дарга, Нарийн бичгийн дарга
5	5	Шинээр ажилд орсон албан хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөрт төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтыг оруулах.	Төсөв шаардлагагүй	Тухай бүр	ЁСДХ-ны гишүүд
	Хоёр.Ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, эрсдэлийг тодорхойлох чиглэлээр				
6	1	Байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчлийн нөхцөл байдлыг тогтоох зорилгоор албан хаагчдаас санал асуулга явуулах	Төсөв шаардахгүй	Улирал тутам	ЁСДХ-ны гишүүд
7	2	Үүсэж болзошгүй ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, дүн шинжилгээ хийх чиглэлээр холбогдох нэгж, ажилтанд зөвлөмж өгөх.	Төсөв шаардахгүй	Тогтмол	

8	3	Ёс зүйн зөрчилтэй холбоотой албан хаагчдын санал хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авах хайрцаг ажиллуулах.	Төсөв шаардахгүй	Тогтмол	
	Гурав. Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд заасан дотоод зохион байгуулалтын ажлууд				
9	1	Ёс зүйн гомдол, мэдээлэл, гаргасан дүгнэлт, томилох эрх бүхий этгээд зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг цахим системд, бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх.	Төсөв шаардахгүй	Тухай бүр	ЁСДХ-ны Дарга, Нарийн бичгийн дарга
10	2	Гомдол, мэдээлэлтэй холбоотой бүрдүүлсэн нотлох баримт, холбогдох шийдвэрийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хувийн хэрэг бүрдүүлж, архивлах.	Төсөв шаардахгүй	Тогтмол	
11	3	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, тайланг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх, цахим хуудсанд байршуулж, ил тод мэдээлэх.	Төсөв шаардахгүй	Сар бүр, Дараа оны 1 дүгээр сард	